

# "ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО" -ЫН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 03 дугаар сарын 22

## **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2018 онд хийсэн ажлын биелэлт, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох статистик мэдээ, мэдээллийг ашиглав.

## **ХОЁР. БОДЛОГЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

"Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" нь УИХ-ын 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан.

### **Бодлогын зорилго**

Бодлогын зорилго нь дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино.

### **Бодлогын зорилтууд**

**Зорилт 1.** Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх;

**Зорилт 2.** Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон "Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал"-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах;

**Зорилт 3.** Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх;

**Зорилт 4.** Аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих;

**Зорилт 5.** Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих;

**Зорилт 6.** Бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;

**Зорилт 7.** Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

**Зорилт 8.** Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх.

### **Бодлогыг хэрэгжүүлэх үе шат**

**I үе шат /2015-2020 он/:** Үндэсний үйлдвэрлэлийг хамгаалж, үндсэн түүхий эдийг дотооддоо боловсруулж, техник, технологийг нутагшуулан экспортыг дэмжих, импортыг орлох аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

**II үе шат /2020-2025 он/:** Экспорт давамгайлсан аж үйлдвэрийн бүтцийг бий болгож өндөр технологи, машин, тоног төхөөрөмж, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

**III үе шат /2025-2030 он/:** Мэдлэгт суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлж, үйлчилгээ болон технологийн экспортыг дэмжин хөгжүүлнэ.

### **Бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

❖ Хүн амын амьжиргааны түвшин сайжирч, үндэсний аюулгүй байдлын баталгаа нэмэгдэнэ.

❖ Үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дотоодын хэрэгцээгээ хангасан экспортлогч

орон болж, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

❖ Боловсруулах болон үйлчилгээний салбарын бүтээгдэхүүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ 2014 оны түвшнээс 2 дахин нэмэгдсэн байна.

❖ Үйлдвэрлэл, технологийн парк байгуулагдаж, үйлдвэрийн кластер, логистикийн сүлжээ

хөгжинө.

❖ Судалгаа хөгжлийн боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулж үндэсний баялгийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.

❖ Аж үйлдвэрийн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бий болж,

экспортын зах зээл өргөжинө.

❖ Үндэсний түүх, соёлын онцлогийг агуулсан, шинэ бүтээл, бүтээгдэхүүн, үйлчилгээний

үйлдвэрлэл хөгжсөнөөр эдийн засагт тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэж, соёлын нөлөө олон улсад бэхэжсэн байна.

## ГУРАВ. БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

"Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" нь 2016 оны 06 дугаар сарын 19-нд батлагдсанаас хойш бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй явж ирсэн.

Тайлант 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн ХХААХҮ-ийн сайд, УУХҮЯ-ны сайдын хамтарсан А-79/А93 тоот тушаалаар "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын 1 дүгээр үе шатны/2015-2020 он/ үйл ажиллагааг 6 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган төлөвлөгөөг батлуулсан байна.

Тус 2018 онд төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ зохион байгуулж ажиллахаар тусгаж, хэрэгжүүлсэн байна.

## "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын 2018 оны хэрэгжилт 73.4 хувиар үнэлэгдэв.

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Хүснэгт 1				Үнэлэх боломжгүй	Биелэлт, хувиар
			100%	70%	40%	0%		
1	I зорилт	12	4	1	5	-	2	67.0
2	II зорилт	3	1	2	-	-	-	80.0
3	III зорилт	11	-	7	4	-	-	59.1
4	IV зорилт	2	-	2	-	-	-	70.0
5	V зорилт	2	2	-	-	-	-	100.0
6	VI зорилт	5	1	2	2	-	-	64.0
	<b>Нийт</b>	<b>35</b>	<b>8</b>	<b>14</b>	<b>11</b>		<b>2</b>	<b>73.4</b>

"Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /Хүснэгт 1/-ийн удаашралтай, үр дүнгүй, үнэлэх боломжгүй арга хэмжээг тухайн зорилт бүрээр авч үзвэл:

**Нэг. Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:**

Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан 12 арга хэмжээний биелэлт 67 хувиар үнэлэгдэв. Эдгээр арга хэмжээнээс дараахь 4 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Үүнд:

➤ ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг батлуулсан

бөгөөд одоогийн байдлаар орон нутагт баригдах үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажил 100 хувь хийгдэж үйлдвэрлэл эхэлсэн 7 аймгийн 9 үйлдвэр, 70-90 хувийн гүйцэтгэлтэй 13 аймгийн 14 үйлдвэр, бүтээн байгуулалтын тодорхой ажил хийгдэж эхэлсэн 50 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй 6 аймгийн 7 үйлдвэр, нийт 30 үйлдвэр байна. Үүнээс 3 үйлдвэрт өргөтгөл хийгдэж, 27 үйлдвэр нь шинээр байгуулагдсан байна.

➤ ЗГ-ын 2018 оны 47 дугаар тогтоолоор “Ноолуур” хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: МУХБ-ны эх үүсвэрээр зээл олгохоор ХХААХҮЯам болон МУХБ-ны хооронд 2018.03.13-ны өдөр 180313/06-070 дугаар бүхий “Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл тохирох гэрээ” –г байгуулж, нийт 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосны үр дүнд ноолуур боловсруулах салбарын түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин суурь түвшинд буюу 2014 онд 11.5% байсан бол 2018 оны байдлаар 35.8%-д хүрсэн. Ноолуурын нийт экспорт 2018 онд өмнөх оноос 21.2 хувиар буюу 68.3 сая доллараар өссөн байна.

➤ Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүнд үйлдвэрийн эрх зүйн асуудлуудыг тусгуулах саналыг боловсруулан 2018.04.11-ний өдөр Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт болон Хуулийн хэлтэст хүргүүлэн холбогдох зохицуулалтыг тусгуулсан. Уг хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн бөгөөд УИХ-ын холбогдох Байнгын хороогоор хэлэлцэгдэж байна.

➤ Тус 2018 онд ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэд ЖДҮХС-ийн эргэн төлөлтөөс 27.8, улсын төсвөөс 70.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж, нийт 97.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Тус онд нийт 212 зээлдэгчид 97.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан 2018 онд нийт 584 харилцагчийн 142.2 тэрбум төгрөгийн зээлээс 64.3 тэрбум төгрөгийн зээлд батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн. Нийт 584 зээлдэгчид батлан даалт гаргасны 79.5 хувь буюу 390 нь Улаанбаатар хот, 20.5 хувь буюу 194 нь орон нутгийн зээлдэгч байна. Нийт гаргасан батлан даалтын 59.6 хувийг үйлдвэрлэл, 16.8 хувийг үйлчилгээ, 23.6 хувийг худалдааны салбар эзэлж байна. Мөн 20.1 хувь буюу 177 зээлдэгч нь банкны эх үүсвэртэй, 79.9 хувь буюу 407 зээлдэгч нь төслийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс зээл авсан.

### **Удаашралтай хэрэгжиж буй арга хэмжээнүүд**

1. Худалдааны тухай хуулийг боловсруулах ажил өмнөх 2016-2017 онд тодорхой ахиц гараагүй тул, 2018 онд хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг дахин шинээр байгуулсан. Тус онд хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тандан судалгаа, дотоод худалдааны өнөөгийн байдлын судалгааны ажлуудыг зөвлөх үйлчилгээгээр хийлгэсэн. Хуулийг 2019 онд УИХ-д өргөн барьж батлуулах ёстой тул энэхүү ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2. Дээрх хууль батлагдаагүйгээс дагаж гарах журмууд гарах боломжгүй хойшлогдож байгаа тул үнэлэх боломжгүй байна.

3. Мөн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулан СЯ-нд хүргүүлсэн боловч Сангийн сайдын зүгээс тус хуулийн нэмэлт өөрчлөлтийг хойшлуулах санал ирүүлсний дагуу энэ ажил хугацаа алдаж байна.

“Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 193 дугаар тогтоолоор батлуулсан.

Харин санхүүгийн түрээс, зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын явц удаашралтай байна.

Худалдааны тухай хууль батлагдаагүй байгаа тул зорилтот түвшинд тусгасан хуулийн хэрэгжилттэй холбогдох журмын төслүүдийг боловсруулж, батлуулсан байна гэсэн заалтыг үнэлэх боломжгүй байна.

**Дүгнэлт:** Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр 2018 онд өмнөх оноос харьцангуй ахиц гарсан. Үүнд:

*ХХААХҮ-ийн сайд, УУХҮЯ-ны сайдын хамтарсан А-79/А/93 тушаалаар Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний 1 дүгээр шатны төлөвлөгөөг батлуулсан.*

*Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг, “Хүнд үйлдвэрийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулсан.*

*Мөн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүнд үйлдвэрийн эрх зүйн асуудлуудыг тусгуулах саналыг боловсруулан 2018.04.11-ний өдөр Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт болон Хуулийн хэлтэст хүргүүлэн холбогдох зохицуулалтыг тусгуулсан. Уг хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн бөгөөд УИХ-ын холбогдох Байнгын хороогоор хэлэлцэгдэж байна.*

**Хоёр. Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах зорилтын хүрээнд:**

Уг зорилтын хүрээнд төлөвлөсөн 3 арга хэмжээний биелэлт 80 хувиар үнэлэгдэв. Үүнээс: 1 арга хэмжээ бүрэн, 2 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, өмнөх оноос харьцангуй ахиц гарсан байна. Үүнд:

Үндэсний хөгжлийн газар/ҮХГ/-аас Аж үйлдвэрийн цахим мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн Монгол Улсын аж үйлдвэржилтийн хөгжил, байршлын орон зайн нэгдсэн төлөвлөлт, зураглалыг ArcGIS программ дээр боловсруулж Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн паркийн оновчтой байршлыг тодорхойлсон.

Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах ажлын хүрээнд Үйлдвэржилтийн хөгжил, байршлын бодлогын судалгааны ажлыг ҮХГ-ын даргын 2018 оны А-48, А-49 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулж, зөвлөх сонгон шалгаруулж, зөвлөхүүдээр гүйцэтгүүлсэн байна.

Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 8 сарын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгтэй ҮХГ хамтран ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн төслийг боловсруулж дуусган яамдаас санал авч байна. 2018 оны 12 дугаар сарын 06-нд олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн байна.

**Гурав. Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:**

Уг зорилтын хүрээнд 11 арга хэмжээний биелэлт 59.1 хувиар үнэлэгдсэн. Тус онд төлөвлөн хэрэгжүүлсэн 7 арга хэмжээ 70 хувь, 4 арга хэмжээ 40 хувийн биелэлттэй гарсан.

Тус 2018 онд шинээр хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр 5 арга хэмжээг эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн шинээр барих үйлдвэрүүдийн холбогдох судалгаа, ТЭЗҮ, сонгон шалгаруулалтын ажлыг гүйцэтгэсэн зэрэг бэлтгэл ажлыг хангах чиглэлээр нилээд ажлуудыг зохион байгуулж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд УУХҮЯ-ны дэргэд төслийн нэгж ажиллаж, Төслийн нэгжээс 2018.09.26-ны өдөр Өмнөговь аймгийн ИТХТ-ын ээлжит хуралдаанд төслийн талаар танилцуулга хийж, ИТХТ-ийн тус өдрийн 126 дугаар тогтоолоор үйлдвэрийн газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг дэмжсэн. Түүнчлэн үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийг 2018.08.13-ны өдөр зарласан. Тендерийн үнэлгээний

хороо ажиллаж гүйцэтгэгчийг 2018.09.13-ны өдөр шалгаруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

- Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ нь 2018 оны 6 дугаар сард хийгдэж дууссан бөгөөд ТЭЗҮ-ийн дагуу баригдах үйлдвэрийн өртгийг бууруулах чиглэлээр холбогдох зөвлөлдөх уулзалт, хэлэлцээрийг хийсэн. Газрын тосны үйлдвэр барих хүрээнд хийгдэж буй “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн хүнд даацын тусгай зориулалтын автозамын бүтээн байгуулалт 35%, ЦДҮС-ний ажлын гүйцэтгэл 85%, Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох салбар төмөр замын гүйцэтгэл 20%-тай байна.

- Ангижруулсан төмрийн үйлдвэр ба гангийн үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх хүрээнд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь жилд 500.0 мянган тонн шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажил, гангийн үйлдвэрт өргөтгөл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэн жилд 350.0 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Үүнд: Төмрийн хүдрээс ган гарган авах технологийн судалгаа, түүхий эд, материалын болон технологийн туршилтууд, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэв. Мөн Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн ТЭЗҮ-ийг Канад Улсын “Hatch” компани хийж гүйцэтгэсэн ба “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ”-г Монгол Улсын “Экотон” ХХК болон “Ажид” ХХК, “Экосфер” ХХК-иуд гүйцэтгэн 2019 онд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

- Ширэм ба гангийн үйлдвэрийг Дорноговь аймгийн Айраг суманд 2017 онд барьж эхлүүлсэн ба 76x27x9 м хэмжээтэй дулааны боловсруулалтын цехийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн суурийн ажлын гүйцэтгэл 100%, 126x30x9 м цутгуурын цехийн барилга 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Мөн домен зуухны 120 м3 суурийн цутгалтын ажлыг эхлүүлсэн ба төмрийн хүдрийн бөөнцөгийн талбайн газар шорооны ажлыг хийж гүйцэтгэв. Тоног төхөөрөмжүүдийг БНХАУ-д захиалан хийлгүүлж байгаа ба тээвэрлэлт таталт, угсралт суурилуулалтын ажлыг 2019 оны 1-р улиралд эхлүүлж 3 дугаар улиралд дуусган, туршилт тохируулгын ажлыг хийж, үйлдвэрийг 2019 онд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

- “Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөл” сэдэвт зөвлөх үйлчилгээний Үнэлгээний хороо 2018.04.24-ний өдөр хуралдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай 2018.05.17-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж, эцсийн тайланг 2018.12.13-ны өдөр хүлээн авсан.

Мөн 2016 оноос хойш удаашралтай хэрэгжиж байсан хөнгөн үйлдвэрийг кластераар хөгжүүлэх чиглэлээр тодорхой үр дүн гарсан байна. Дундговь, Төв аймгийн хонины ноосоор Могол ноос ХХК утас ээрч, ээрсэн утсаа Блю скай ХХК-д өгч даавуу үйлдвэрлүүлж, зузаан драпаар нь пальто, нимгэн даавуугаар нь дээрх 2 аймгийн сурагчийн дүрэмт хувцас болон ажлын хувцас үйлдвэрлэн кластерийг бий болгосон.

### **Удаашралтай хэрэгжиж буй арга хэмжээнүүд**

Дараахь арга хэмжээнүүдийг 2016 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжилт хангалтгүй, удаашралтай явж ирсэн. Үүнд:

1. Аж үйлдвэрийн салбарын тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр судалгааны ажлуудыг хийлгэсэн байх бөгөөд уг судалгааг үндэслэн нэгдсэн сүлжээний загвартай болох чиглэлээрх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2. Үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцэд ногоон эрчим хүч ашиглах, хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих чиглэлээр дахин ашиглах цэвэрлэсэн усны техникийн шаардлагын стандартыг боловсруулж батлуулсан, хамгийн их бохирдол гаргадаг “Арьс ширний үйлдвэрийн хаягдал усны стандарт, боловсруулсан арьс ширэнд агуулагдах хорт бодисыг тодорхойлох аргачлал”

судалгааг, “Ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрлэлээс хаягдал ус, түүнийг дахин ашиглах” нь судалгааг тус тус хийлгэсэн эхлэл байгаа ч шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх ажил удаашралтай байна. ҮХГ-аас ирүүлсэн биелэлтээс үзэхэд энэ чиглэлээр хийхээр төлөвлөсөн ажлаа бичсэн байх бөгөөд зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаагүй, бусад хамтран хэрэгжүүлэгч ЭХЯ, БХБЯ, БОАЖЯ -даас тайлан мэдээг ирүүлэхгүй, хамтын ажлын уялдаа холбоо маш хангалтгүй байгааг тэмдэглэж байна.

**Дүгнэлт:** Хүнд үйлдвэрийн чиглэлээр хийгдэх томоохон ажлуудыг эхлүүлсэн байна. Үүнд: Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулах, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулсан, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн гангийн үйлдвэрт өргөтгөл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэн жилд 350.0 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

Орон нутагт түүхий эд, тордолтын цэг байгуулах, түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх судалгааг хийлгэсэн. 4 аймагт гадаадын төслөөр 10 агуулах, мөн 56 хоршоонд дэмжлэг үзүүлж түүхий эд бэлтгэн нийлүүлэх агуулахын итгэмжлэл олгосон байна.

**Дөрөв. Дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

Зорилтын хүрээнд 2 ажил төлөвлөгдөн эдгээр арга хэмжээ 70 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэв. Үүнд: Инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээний хүрээнд шинэ технологи нэвтрүүлэх, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр 2018 онд тодорхой үр дүнд хүрсэн байна. Тухайлбал:

✓ “Protein trade” ХХК нь яс дахин боловсруулах үйлдвэрийг Италийн Impianti carrere компанийн бүрэн автомат тоног төхөөрөмжийг суурилуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн.

➤ “Өндөр ахын өргөө” ХХК нь Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэгт БНХАУ-ын 100 % хөрөнгө оруулалттай, хоногт 10 тн хуванцар сав дахин боловсруулж хуванцар түүхий эд бэлтгэх хүчин чадалтай үйлдвэр байгуулагдан технологийн туршилтаа хийгээд байна. Тус үйлдвэр бүтээгдэхүүнээ БНХАУ-ын Хэбэй мужид экспортлох юм.

➤ **Монпеллетс” ХХК** нь Монгол хурганы болон ахрын ноосоор **био бордоо** үйлдвэрлэн Берлин хотын Хумболдын Их сургуультай 2005-2007 онд хамтран технологи инновацийн бүтээгдэхүүн гаргасан. Төв аймгийн Эрдэнэ суманд орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж суурилагдсан үйлдвэрээ 2018 оны 9-р сард байгуулан, Герман Япон, Солонгос болон дотоодын зах зээлд нийлүүлж байна. Уг бордоо нь экологийн цэвэр бүтээгдэхүүнээс гадна ургацыг 2-3 дахин нэмэгдүүлдэг, баруун Европ, Азийн зарим оронд экспортод гардаг, зах зээлийн өндөр үр ашигтай инновацийн бүтээгдэхүүн болоод байна.

➤ Уламжлалт үндэсний монгол дээлийг орчин үеийн нано технологиор гарган авсан гал болон ус нэвтэрдэггүй материалаар “Хадлан” дээлийг “**Three flames**” ХХК ны загвар зохион бүтээгчид бүтээн, инновацийн эрэлт өндөр бүтээгдэхүүн болоод байна. Дотоод зах зээлээс гадна АНУ, Герман, Францад эрэлттэй, борлуулалт өндөр бүтээгдэхүүн болсон.

➤ Бүх төрлийн ахуйн хог хаягдал, нүүрсийг шатааж, ахуйн хэрэглээний газ үйлдвэрлэн, дулааны энерги гаргах “**АББАТ**” /Ахуйн бохирдлыг бууруулан ашиглах төсөл/-ийг дэмжин хэрэгжүүлэгч **МегаВүүд ХХК**-д санхүүгийн дэмжлэг үзүүлж АХБ болон Монгол банкны удирдлагыг газар дээр нь очиж үзүүлэв. Уг төслийн туршилтын арга хэмжээ амжилттай болсон. Дээрх төсөл нь агаарын болон орчны бохирдлыг бууруулах, дулаан эрчим хүч үйлдвэрлэх эдийн засгийн болоод нийгмийн өндөр үр ашигтай чухал төсөл юм. Мөн тус компани нь ойгоос гарах хаягдлыг ашиглан инновацийн бүтээгдэхүүн **МД хавтанг** 2-3 төрлөөр үйлдвэрлэхээр үйлдвэрлэлийн барилгаа барьсан.

➤ Голланд Улсын 60 хувийн хөрөнгө оруулалттай MiM ХХК-ийн адууны дэл сүүлний үйлдвэр байгуулагдав. Уг үйлдвэрт 30-40 иргэн, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах боломжтой боллоо.

➤ ХХААХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн Сайдын нэрэмжит грантыг “Хагас нарийн ээрэх системээр үйлдвэрлэсэн 48/2 номерын ноолууран ээрмэлээр сүлжсэн оёдолгүй, дотуур сүлжмэл бүтээгдэхүүн” зэрэг 5 бүтээлд олгов. ХХААХҮ-ийн салбарын хэрэгжүүлэх боломжтой судалгаа, зүгшрүүлэлтийн ажил /инновацийн төсөл/-ын Хөдөө аж ахуйн -22, аж үйлдвэрийн салбарын 8 төслийн ирүүлснээс Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”-ээр Мал эмнэлгийн хүрээлэнгийн “Гарааны ветбиотек” компаний “Делтамон Пу-Рон” /малын гадна шимэгчийн эсрэг үйлчилгээтэй дусаалга эм/ шалгарч 60,0 сая төгрөгөөр шагнуулсан.

➤ “Шангрила” зочид буудлын хог хаягдлыг анхан шатны ангилан ялгах менежментийг МХХДБҮХолбоотой хамтран 2018 оны 05 дугаар сард хийж, ялгасан хоёрдогч түүхий эдийг холбогдох дахин боловсруулах үйлдвэр өөрийн тээврээр авч байх зохицуулалт хийсэн.

**Тав. Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, шинэ чадавх, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд:**

Тус зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд бүрэн хэрэгжсэн байна.

**Дүгнэлт:** Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой үр дүнд хүрч, үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгож, соёлын биет болон биет бус өвүүдийг ЮНЕСКО-ийн өвийн жагсаалтад 3 биет бус өвийг бүртгүүлсэн байна.

**Зургаа. Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүч бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:**

Зорилтыг хэрэгжүүлэхээр 5 арга хэмжээ 64 хувийн биелэлттэй үнэлэгдсэнээс 1 арга хэмжээ бүрэн, 2 арга хэмжээ 70 хувь, 2 арга хэмжээ 40 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Үйлдвэрийн инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр холбогдох сургалтад хамруулж байгаа хэдий ч системтэй арга хэмжээ авах, аж үйлдвэрийн салбарын хүний нөөц мэргэжилтэй ажилтан бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийг яаралтай боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

1. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 2018 оны хэрэгжилтийн ерөнхий дундаж үнэлгээ **73.4** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” бөгөөд өмнөх 2017 оноос 25.1 пунктээр өссөн байна.

2. Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр өмнөх оноос харьцангуй ахиц гарсан. Үүнд:

- ✓ ХХААХҮ-ийн сайд, УУХҮЯ-ны сайдын хамтарсан А-79/А/93 тушаалаар Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний 1 дүгээр шатны төлөвлөгөөг батлуулсан.
- ✓ Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг, “Хүнд үйлдвэрийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулсан.
- ✓ Мөн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүнд үйлдвэрийн эрх зүйн асуудлуудыг тусгуулах саналыг боловсруулж, уг хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн бөгөөд УИХ-ын холбогдох Байнгын хороогоор хэлэлцэгдэж байна.

3. “Хүнд үйлдвэрийн чиглэлээр хийгдэх томоохон ажлуудыг 2018 онд эхлүүлсэн байна. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулсан, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн гангийн үйлдвэрт өргөтгөл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэн жилд 350.0 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах

*бэлтгэл ажлыг эхлүүлсэн байна.*

4. Хөнгөн үйлдвэрийг кластераар хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь, хэмжээг нэмэгдүүлэх, мөн инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлээр өмнөх онтой харьцуулахад тодорхой үр дүнд хүрсэн байна. Эдгээр үр дүнг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах

5. Үйлдвэрийн инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр холбогдох сургалтад хамруулж байгаа хэдий ч системтэй аж үйлдвэрийн салбарын хүний нөөц мэргэжилтэй ажилтан бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна.

## **ТАВ. ЗӨВЛӨМЖ**

1. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг /2016-2020 он/ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүрээр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлж боловсруулан, батлуулахыг БТГ-т;
2. Бодлогын 2016-2018 онд удаашралтай болон хэрэгжээгүй арга хэмжээг 2019 оны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажиллахыг БТГ, ХөнҮБХЗГ-т;
3. Бодлогыг хамтран хэрэгжүүлэх яамдууд, Үндэсний хөгжлийн газар, холбогдох ТББ-уудын оролцоог хангаж, хэрэгжилтийг эрчимжүүлэхийг БТГ, ХөнҮБХЗГ-т;
4. Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, шинээр байгуулагдах үйлдвэрүүдийг санхүү, хөрөнгө оруулалтаар дэмжих, эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэхийг БТГ, ХөнҮБХЗГ,
5. “Ноолуур хөтөлбөр” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, боловсруулах үйлдвэрүүдэд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр Хөгжлийн банктай хамтран ажиллаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ХөнҮБХЗГ-т
6. Хөнгөн үйлдвэрийг кластераар хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохыг БТГ-т,
7. “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийг боловсруулж батлуулахыг БТГ, ХөнҮБХЗГ-т
8. БТГазар болон бодлогыг хэрэгжүүлэгч газрууд/хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд, яамны газрууд/-ын хоорондын уялдаа холбоог сайжруулж, төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнд хүргэх, тайланг хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавьж ажиллахыг ТЗУГ-т тус тус зөвлөж байна.



**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН  
ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ  
(2018 оны жилийн эцсийн байдлаар)**

2019.03.22

д/д	Бодлогын зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2015 он/	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл, хувь	Дэлгэрэнгүй тайлбар хэрэгжүүлээгүй шалтгаан
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	Худалдааг дэмжсэн хууль, эрх зүйн актыг шинээр боловсруулан баталж мөрдүүлэх	Худалдааны тухай хууль /Хуулийн үзэл баримтлалын төсөл / - Холбогдох судалгаа	2016-2019	шинээр боловсруулсан хууль, эрх зүйн акт-1 хуулийн үзэл баримтлалын төсөл, судалгаа боловсруулсан байх	Худалдааны тухай хууль байхгүй /Хуулийн үзэл баримтлалын төсөл / Холбогдох судалгаа	Худалдааны тухай хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Худалдааны салбарыг бодлогыг шинэ түвшинд гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-586 тоот тушаалаар “Худалдааны тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, 12 дугаар сарын 05-ны өдөр хуулийн төслийн ажлын хэсгийн анхны хурлыг зохион байгуулав. Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тандан судлах судалгааг зөвлөх үйлчилгээгээр хийлгэлээ. Худалдааны тухай хуулийн төслийн багц судалгаа”-г зөвлөх үйлчилгээгээр хийлгэн 2018 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр №20181130-2 тоот актаар хүлээн авлаа. Мөн дотоод худалдааны салбарын нөхцөл байдлын судалгааг зөвлөх үйлчилгээгээр хийлгэн 2018 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр №20181130-1 тоот актаар хүлээн авсан. Дээрх судалгаанд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж байна.	40	
2		Худалдааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тарифын болон тарифын бус зохицуулалтыг олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэх	Хуулийн хэрэгжүүлэхтэй холбогдох журам	2016-2020	шинээр боловсруулсан эрх зүйн акт-1	Худалдааны талаар хууль, эрх зүйн зохицуулалт дутмаг	Хуулийн хэрэгжилттэй холбогдох журмын төслүүдийг боловсруулж, батлуулсан байна.	Хууль батлагдаагүй тул холбогдох журам боловсруулах боломжгүй.	ҮБ-гүй	

3		Татварын бодлогын талаар эрх зүйн орчныг сайжруулах.	Сангийн яамнаас боловсруулсан Татварын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах санал	2016-2018  2018	Багц санал-1  /саналын тусгуулах /	Татварын бодлогын үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдэд таатай бус	Татварын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал тусгуулсан байна	ЗГ-ын 2017 оны 168 дугаар тогтоолоор Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх ЖДҮ-ийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг тусгаж батлуулав. Уг хууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Хуулийн хүрээнд ЖДҮ-ийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортын гаалийн албан татвараас чөлөөлснөөр 2018 онд 28.2 тэрбум төгрөгийн тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл импортолж 1.4 тэрбум төгрөгийн гаалийн албан татварын хөнгөлөлтийг эдэлсэн байна. Ийнхүү 2018 онд 451 аж ахуйн нэгж тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийхэд дэмжлэг үзүүлсэн. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд 1 хувийн татвар ногдуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг 15 хувиар давуулан тооцохоор тусган УИХ-аар хэлэлцүүлж байна. Санхүүгийн түрээсийн тухай хуулийн дагуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай байгаа тоног, төхөөрөмжийн судалгааг гарган лизингийн нөхцөлөөр олгох арга хэмжээг судалж байна.	70	
4			Хуулийн төсөл	2018-2020	эрх зүйн акт-1	Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн	Автомашин, нийтийн тээвэр, ХАА-н машин, механизмыг угсрах зориулалттай тоног төхөөрөмжийг	Автомашин, нийтийн тээвэр, ХАА-н машин, механизмыг угсрах зориулалттай тоног төхөөрөмжийг импортлоход Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн төсөлд саналаа тусган, холбогдох тандан судалгааны ажлыг зохион байгуулан боловсруулалт хийж дууссан. “Зарим барааны гаалийн албан татварыг нэмэгдүүлэх болон хөнгөлөх барааны	40	

						төслийг боловсруулах шаардлагатай	импортлоход Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж батлуулна.	жагсаалт"-ыг үйлдвэрлэлийн нөөц, хүчин чадал ашиглалтын төвшинд уялдуулан боловсруулж, холбогдох судалгааг хийж, ГХЯ болон Гаалийн тарифын зөвлөлд 2018 оны 1 сард хүргүүлсний дагуу гаалийн тарифт өөрчлөлт оруулах үндэслэл, судалгааг эцэслэн боловсруулж, 2019 оны 2-р улиралд холбогдох байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна. -УИХ-ын 27-р тогтоолоор Засгийн газарт зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох эрхийг олгосны дагуу хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний 1-23-р бүлгийн барааны импортын татварыг нэмэгдүүлэхээр санал боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн.		
5		“Үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийн техник технологийг сайжруулах.	Техник технологийг сайжруулсан байгууламж	2018-2020	Эрх зүйн акт-1	Цэвэрлэх байгууламжийн техник технологийг сайжруулах шаардлагатай	Үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийн техник технологийг сайжруулсан байх.	-Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх бохир усны стандартыг хангуулахаар арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хаягдал бохир усыг урьдчилан цэвэрлэх ажил дээр (SECiM)” төслийн хүрээнд НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагаас ирсэн олон улсын байгаль орчны аудитортай хамтран уг урьдчилан цэвэрлэх байгууламж болон арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд богино хугацааны үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж, холбогдох яам, агентлагууд, үйлдвэр, аж ахуйн нэгжид хүргэв. -Цэвэршүүлсэн усыг эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэхээр БХБЯ-ны Ажлын хэсэгт ажилласан. Дахин ашиглах цэвэрлэсэн ус Техникийн ерөнхий шаардлага MNS 6734:2018 стандартыг 2018 оны 6 сард батлуулав. -“Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй XVI.1.1. “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/” ажлын ТЭЗҮ, зураг, төсөв, төсөл боловсруулах, тоног төхөөрөмжид шаардлагатай засвар үйлчилгээ хийж угсарч	40	

								суурилуулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, шалгарсан "Саруул цамхаг" ХХК-тай гэрээ байгуулсан. Хяналтын гэрээг Ховд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай байгуулав. Гүйцэтгэгч компани 710 сая төгрөгний ажлыг хийсэн. Энэ нийт барих байгууламжийн ажлын 26 хувийг эзэлж байна.		
6		Зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг сайжруулах.	Хуулийн хэрэгжилттэй холбогдох журмын төслүүдийг боловсруулж, батлуулах	2016-2019 /2018/	эрх зүйн акт-1	Санхүүгийн түрээс, зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчин хангалтгүй	Санхүүгийн түрээс, зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг сайжруулах.	Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. Тус хуулийн төсөлд зээлийн батлан даалтын хэмжээг 80 хувь болгохоор тусгасан. Сангийн сайдын зүгээс тус хуулийн нэмэлт өөрчлөлтийг хойшлуулах санал ирүүлсэний дагуу 2019 онд хэрэгжүүлэхээр болсон.	40	
7		Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг санхүү зээл, зээлийн давхар батлан даалтын бодлогоор дэмжих	Хуулийн хэрэгжилттэй холбогдох журмын төслүүдийг боловсруулж, батлуулах	2018-2020	Санхүүжүүлэх төслийн тоо	ЖДҮХөгжүүлэх чиглэлээр санхүүгийн хүртээмж хангалтгүй, давхар батлан даалтын хөрөнгө оруулалт байхгүй байна.	ЖДҮХС-ийн өөрийн хөрөнгийг 200,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх давхар батлан даалтын үйл ажиллагаа эхлүүлэх	Тус 2018 онд ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэд ЖДҮХС-ийн эргэн төлөлтөөс 27.8, улсын төсвөөс 70.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж, нийт 97.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Тус онд нийт 212 зээлдэгчид 97.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. ЖДҮ эрхлэгчдэд олгох зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор ЕСБХБ-тай хамтран банк, санхүүгээс 86.5 сая долларын эх үүсвэрийг банк, санхүүгийн байгууллагуудад олгосон. ХААН банк 30 сая ам. долларын зээлийн гэрээ хийснээс 10.0 сая ам.долларын зээл олгосон. Нэмүү өртгийн сүлжээ бий болгох зорилгоор 15.0 сая ам.долларын зээлийн гэрээ хийснээс, 10.0 сая ам.долларын зээл олгосон.	100	

								<p>Хас банк 40.0 сая ам.долларын хамтарсан зээлийн гэрээ хийсэн.</p> <p>Транскапитал ББСБ 1.5 сая ам.доллар бичил болон жижиг бизнесүүдэд зориулж зээлийн гэрээ хийсэн.</p> <p>- Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан 2018 онд нийт 584 харилцагчийн 142.2 тэрбум төгрөгийн зээлээс 64.3 тэрбум төгрөгийн зээлд батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн. Нийт 584 зээлдэгчид батлан даалт гаргасны 79.5 хувь буюу 390 нь Улаанбаатар хот, 20.5 хувь буюу 194 нь орон нутгийн зээлдэгч байна. Нийт гаргасан батлан даалтын 59.6 хувийг үйлдвэрлэл, 16.8 хувийг үйлчилгээ, 23.6 хувийг худалдааны салбар эзэлж байна.</p> <p>Мөн 20.1 хувь буюу 177 зээлдэгч нь банкны эх үүсвэртэй, 79.9 хувь буюу 407 зээлдэгч нь төслийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс зээл авсан.</p>		
8		<p>Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн хууль, эрх зүйн актыг шинээр боловсруулж батлуулах.</p>	<p>"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр</p>	2016-2018	<p>Үндэсний хөтөлбөр -1</p>	<p>Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай</p>	<p>"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийг боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.</p>	<p>"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны А-129 тоот тушаалаар батлуулан холбогдох яам болон тус яамны газар хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжүүлж байна.</p> <p>2019 оны үндсэн чиглэл, Хөнгөн үйлдвэрлэлийн салбар, Үйлдвэржилт 21:10 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтын 2019 оны төсвийн төслийг боловсруулан батлуулав.</p> <p>Орон нутагт баригдах үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажил 100 хувь хийгдэж үйлдвэрлэл эхэлсэн 7 аймгийн 9 үйлдвэр, 70-90 хувийн гүйцэтгэлтэй 13 аймгийн 14 үйлдвэр, бүтээн байгуулалтын тодорхой ажил хийгдэж эхэлсэн 50 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй байгаа 6 аймгийн 7 үйлдвэр нийт 30 үйлдвэр байна. Үүнээс 3</p>	100	

							<p>Үйлдвэрт өргөтгөл хийгдэж, 27 үйлдвэр нь шинээр байгуулагдсан байна.</p> <p>ЗГ-ын 336 дугаар тогтоолоор баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-ыг шинэчлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудын худалдан авалтын 2018 оны тайлан, жагсаалтыг хүлээн авч, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.</p>			
9			“Ноолуур” хөтөлбөр	2016-2018	Хөтөлбөр-1	Дунд хугацаанд эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж, тогтвортой өсөлтийг хангах зорилгоор хөтөлбөр боловсруулах шаардлагатай	“Ноолуур” хөтөлбөрийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.	Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор "Ноолуур" хөтөлбөрийг батлуулав.	100	
10			Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам	2016	эрх зүйн акт-1	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сантай холбоотой журам боловсруулах шаардлагатай	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг ЗГ-ын 2016 оны 193 дугаар тогтоолоор батлуулсан. Тус сан нь УУХҮЯ-нд харьяалагддаг байсан, ЗГ-ын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Үйлдвэрлэлийг хөгжүүлэх санг татан буулгах шийдвэр гаргасан.	ҮБ-гүй	

11			Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр	2018-2020	Хөтөлбөр-1	Дунд хугацааны бодлого боловсруулах шаардлагатай	Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, батлуулсан байна.	<p>“Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийн төслийн холбогдох судалгаа хийх” зөвлөхийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгчээр шалгарсан “Тэнгэр судалгаа” ТББ-тай 2018.05.17-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж, “Хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийн төсөл”-ийг боловсруулж бэлэн болгов. Энэхүү ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: Хүнд аж үйлдвэрийн хөгжлийн нөхцөл байдлын, нөлөөллийн болон байгаль орчинд нөлөөлөх байдлын урьдчилсан судалгааг боловсруулах ажлыг зохион байгуулав.</p> <p>Хөтөлбөрийн төслийг цахим хуудсанд байршуулж, санал авах ажлыг зохион байгуулав.</p> <p>Хөтөлбөрийн төслийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулав.</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу хөтөлбөрийг дагалдах баримт бичгүүдийн төслийг боловсруулж, яамдаас санал авахаар бэлэн болгов.</p>	40	
12			Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл	2018-2020	Хуулийн төсөл-1	Хүнд үйлдвэрийн тухай хууль байхгүй	Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулсан байна.	<p>Хүнд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалтын асуудлыг Уул уурхайн тухай хуулийн төсөлд нэгтгэн тусгах болсонтой холбогдуулан Уул уурхайн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд хүнд үйлдвэрийн холбогдох өөрчлөлтийг тусгуулах саналыг боловсруулан 2018.04.02-ны өдөр Уул уурхайн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн.</p> <p>Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүнд үйлдвэрийн эрх зүйн асуудлуудыг тусгуулах саналыг боловсруулан 2018.04.11-ний өдөр Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт болон Хуулийн хэлтэст хүргүүлэн холбогдох зохицуулалтыг тусгуулсан. Уг хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар</p>	100	

								дэмжигдсэн бөгөөд УИХ-ын холбогдох Байнгын хороогоор хэлэлцэгдэж байна. Мөн “Хүнд үйлдвэрийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулж, 2018.11.18-ны өдөр салбарын эрдэмтэд, судлаачдын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулав.		
	<b>Зорилт 1-ийн хэрэгжилт</b>	Дүгнэлт: Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр 2018 онд өмнөх оноос харьцангуй ахиц гарсан. Үүнд: ХХААХҮ-ийн сайд, УУХҮЯ-ны сайдын хамтарсан А-79/А/93 тушаалаар Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний 1 дүгээр шатны төлөвлөгөөг батлуулсан. Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг, “Хүнд үйлдвэрийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулсан. Мөн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүнд үйлдвэрийн эрх зүйн асуудлуудыг тусгуулах саналыг боловсруулан 2018.04.11-ний өдөр Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт болон Хуулийн хэлтэст хүргүүлэн холбогдох зохицуулалтыг тусгуулсан. Уг хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн бөгөөд УИХ-ын холбогдох Байнгын хороогоор хэлэлцэгдэж байна.						67.0		
13	Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах	“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-ийг тодорхойлж батлуулах,	“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-ийг тодорхойлсон баримт бичиг	2016-2019	Бодлогын баримт бичиг-1	“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс” тодорхойлог-доогүй	“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-ийг тодорхойлсон баримт бичиг батлагдсан байна.	ҮХГ-аас аж үйлдвэрийн салбарын нэгдсэн төлөвлөлт байршил, хөгжлийн судалгаа хийлгэхээр ажлын даалгаврыг боловсруулан ажиллаж байна. Монгол Улсын хүнд үйлдвэржилтийн газрын зургийг боловсруулах зорилгоор УУХҮЯ, ХХААХҮЯ, АМГТГ, Мэргэжлийн зөвлөх, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/60 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нь мэргэжлийн зөвлөх багтай хамтран ажиллаж, “Монгол Улсын хүнд үйлдвэрлэлийн бүс”-ийг боловсруулсан. Хүнд үйлдвэрлэлийн бүсийн талаар бүх яамдаас санал авч, ажлыг эцсийн байдлаар 2017.11.15-ны өдөр зөвлөх багаас хүлээн авсан. Аж үйлдвэрийн цахим мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн Монгол Улсын аж үйлдвэржилтийн хөгжил, байршлын орон зайн нэгдсэн төлөвлөлт, зураглалыг ArcGIS программ дээр боловсруулж Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн паркийн оновчтой байршлыг тодорхойлсон.	70	



								<p>Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах ажлын хүрээнд Үйлдвэржилтийн хөгжил, байршлын бодлогын судалгааны ажлыг Үндэсний хөгжлийн газрын даргын 2018 оны А-48, А-49 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулж, зөвлөх сонгон шалгаруулж, зөвлөхүүдээр гүйцэтгүүлээд байна.</p> <p>Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 8 сарын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгтэй ҮХГ хамтран ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн төслийг боловсруулж дуусган яамдаас санал авч байна. 2018 оны 12 дугаар сарын 06-нд олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн.</p>		
14		<p>“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-тэй уялдуулан үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох;</p>	<p>“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-тэй уялдуулан үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоосон баримт бичиг</p>	2016-2020	Бодлогын баримт бичиг-1	Үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоогоогүй	<p>“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-тэй уялдуулан үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоосон байна.</p>	<p>2018 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр үйлдвэрийн улсын тооллогын нээлтийг Төрийн ордонд онлайнаар зохион байгуулж, ЗГХЭГ, холбогдох яамд, 21 аймаг, дүүргийн Засаг дарга нар мөн үйлдвэрийн нэгдсэн тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд, үйлдвэр эрхлэгч нийт 1000 орчим хүн оролцов.</p> <p>Аж үйлдвэрийн цахим мэдээллийн системд үйлдвэрлэгчдийн мэдээллийг нэгтгэх ажил үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3647 үйлдвэрийг мэдээллийн системд оруулсан. ҮХГазар, Оюу Толгой компани Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санг ашиглах тухай харилцан ойлголцлын санамж бичигт 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр гарын үсэг зурсан. Тус цахим системийг “Оюу толгой” ХХК-ийн худалдан авалтын “Монголд үйлдвэрлэв” бодлогын хүрээнд Монгол Улсад үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгчид болон зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээ хийх болон худалдан авалтын</p>	100	

							<p>зарыг илүү оновчтой түгээх үйл ажиллагаанд ашиглах боломжтой болох юм. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1 заалтад Монгол улсын Үйлдвэржилтийн газрын зургийг эко систем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргах. гэж заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Үйлдвэржилт-21:100” үндэсний хөтөлбөрийн хүрээнд шинээр байгуулах үйлдвэрүүдийн байршлыг нөөц, зах зээлтэй нь уялдуулан хүчин чадлыг тогтоож, үйлдвэржилтийн зураглал гаргав. Аймгуудын үйлдвэржилтийн өнөөгийн байдлын зургийг аймаг тус бүрээр гаргаж, улсын хэмжээнд 16 салбарын нийт 30 гаруй сэдэвчилсэн зургуудын эхийг бэлтгэж, хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийж гүйцэтгэсэн.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд тогтоосон хүнд үйлдвэрлэлийн бүсийг үндэслэн Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх орон зайн горим, Монгол улсад байгуулах хүнд үйлдвэрүүдийн зургийг боловсруулсан.</p>			
15		Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.	Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн санг бүрдүүлэх.	2016-2018	Мэдээллийн сан-1	5%	100%	<p>Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн сангийн бүртгэлийн ажлыг 2018 оны 1 дүгээр сарын 17 өдөр эхлүүлж одоогийн байдлаар 3647 үйлдвэрийн мэдээллийг бүртгэж авсан.</p> <p>Мөн үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад худалдаа, хөрөнгө оруулагч нарт сурталчлах, мэдээ, мэдээлэл түгээх зорилготойгоор “Герман Олон Улсын Нийгэмлэг” “GIZ”-ийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга төсөлтэй хамтран Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санг хөгжүүлж байна. /Үндэсний хөгжлийн газрын цахим мэдээллийн сангийн хаяг: <a href="http://industry4.nda.gov.mn/">industry4.nda.gov.mn/</a> УУХҮЯ-наас Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор</p>	70	

								<p>үйлдвэрүүдийн тооллогыг хийж, судалгааг эхлүүлсэн.</p> <p>2018 онд Хүнд үйлдвэрийн бүртгэлийг шинэчлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд 79 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, 63 аж ахуйн нэгжийг бүртгэв. Хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэрүүдийн мэдээллийн баазыг бий болгосон.</p>		
	<b>Зорилт 2-ын хэрэгжилт</b>	<p>Дүгнэлт: Үйлдвэрийн улсын тооллогын нээлтийг Төрийн ордонд онлайнар зохион байгуулсан. УХГазар, Оюу Толгой компани Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санг ашиглах тухай харилцан ойлголцлын санамж байгуулсан. Тус цахим системийг “Оюу толгой” ХХК-ийн худалдан авалтын “Монголд үйлдвэрлэв” бодлогын хүрээнд Монгол Улсад үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгчид болон зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээ хийх болон худалдан авалтын зарыг илүү оновчтой түгээх үйл ажиллагаанд ашиглах боломжтой болох юм. Аж үйлдвэрийн цахим мэдээллийн системд үйлдвэрлэгчдийн мэдээллийг нэгтгэх ажил үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3647 үйлдвэр мэдээллээ системд оруулсан.</p>						<b>80.0</b>		
16	<p>Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх</p>	<p>Төмөр, зэс, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн, кокс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх үйлдвэрүүдийг барьж байгуулах ажлыг эхлүүлэх;</p> <p>(УУХҮЯ)</p>	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр: Катодын зэс, алт, мөнгө, хүхрийн хүчил</p>	<p>2018-2020</p>	<p>Хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээ-1, ТЭЗҮ-1</p>	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн талаар ЗГ-ын 2015 онд 247, 318 дугаар тогтоолууд батлагдсан.</p>	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулж, үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлсэн байна.</p>	<p>ЗГ-ын 2017 оны хуралдаанаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоол баталж, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулах, үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмшихээр тус тус тогтоосон.</p> <p>Уг ажлыг хэрэгжүүлэхээр УУХҮЯ-ны дэргэд төслийн нэгж ажиллаж, ЗТХЯам, “Оюутолгой” ХХК болон “Монголын Төмөр Зам” ТӨХК-тай хамтран үйлдвэрийн байршлын газрыг урьдчилсан байдлаар товлон орон нутагт танилцуулсан.</p> <p>Хөрөнгө оруулалт татах чиглэлээр гадаадын компаниудтай уулзалт танилцуулгын ажлыг хийж байна. Хятад-Монголын Засгийн Газар хоорондын комиссын II хуралдаанаар БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос энэ төсөлд Чаиналко компанийг оролцоно гэсний дагуу тус компанийн төлөөлөлтэй хоёр удаа уулзалт хэлэлцүүлгийг хийсэн. Төслийн нэгжээс 2018.09.26-ны өдөр Өмнөговь аймгийн ИТХТ-ын ээлжит хуралдаанд</p>	40	

							төслийн талаар танилцуулга хийж, ИТХТ-ийн тус өдрийн 126 дугаар тогтоолоор үйлдвэрийн газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг дэмжсэн. Түүнчлэн үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан. Дээрх материалууд бүрдсэн учир ЗББҮ-ийн төсөлд Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулахаар БОАЖЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийг 2018.08.13-ны өдөр зарласан. Тендерийн үнэлгээний хороо ажиллаж гүйцэтгэгчийг 2018.09.13-ны өдөр шалгаруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна.			
17			Газрын тосны үйлдвэр (ЕВРО-4, 5 стандартын шаардлага хангасан автобензин, дизель түлш, онгоцны түлш, шингэрүүлсэн шатдаг хий, мазут болон бусад дагалдах бүтээгдэхүүн)	2018-2020	Нарийвчилсан ТЭЗҮ-1 зураг төсөл-1	Газрын тосны үйлдвэрийн ТЭЗҮ урьдчилсан судалгаа хийсэн.	Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, үйлдвэрийн дэд бүтэц, барилгын ажлыг эхлүүлсэн байна.	ЗГ-ын 2017 оны 59 дүгээр тогтоолоор БНЭУ-ын ЗГ-аас олгох 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийг ЗГ-ын 2017 оны 92 дугаар тогтоолоор байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Хоёр улсын ЗГ-ын хооронд байгуулах зээлийн ерөнхий хэлэлцээрийг УИХ-аар 2017 оны 05 дугаар сард баталсан. ЗГ-ын зүгээс “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлж, Зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг 2017 оны 02-08 дугаар сарын хооронд Энэтхэг Улсын Эксим банкттай хамтран зохион байгуулсан бөгөөд сонгон шалгаруулалтад БНЭУ-ын “Инженерс индиа лимитед” компани шалгарч УУХҮЯам болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай	40	

							зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 08 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан. УУХҮЯ-ны зүгээс нарийвчилсан ТЭЗҮ-ний ажлын гүйцэтгэлд хяналт тавин, ТЭЗҮ-ийн эхлэлийн тайланг 2017 оны 11 дүгээр сард хүлээн авсан. Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компанийн туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй "Престиж Инженеринг" ХХК үйлдвэрийн байршил, дамжуулах хоолойн трассын төлөвлөлттэй холбоотой байрзүй, геодези, инженер-геологи, усны судалгааны ажлуудыг орон нутагт 2017 оны 11 дүгээр сараас эхлэн гүйцэтгэж байна. Үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ нь 2018 оны 6 дугаар сард хийгдэж дууссан бөгөөд ТЭЗҮ-ийн дагуу баригдах үйлдвэрийн өртгийг бууруулах чиглэлээр хоёр тал удаа дараа зөвлөлдөх уулзалт, хэлэлцээрийг хийсэн. Хэлэлцээрийн хүрээнд ТЭЗҮ-ийг 2018 оны 11 дүгээр сарын 15-наас өмнө УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэхээр тохиролцсон ба цаашид төслийг эрчимжүүлэх үүднээс төслийн менежментийн зөвлөхийг сонгох, зөвлөхийг УБ хотод байршуулах ажлуудыг шат дараатайгаар хийхээр төлөвлөж байна. Газрын тосны үйлдвэр барих хүрээнд хийгдэж буй “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн хүнд даацын тусгай зориулалтын автозамын бүтээн байгуулалт 35%, ЦДҮС-ний ажлын гүйцэтгэл 85%, Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох салбар төмөр замын гүйцэтгэл 20%-тай байна.		
18		Төвийн бүсэд 500.0 мян.тн/жил хүчин чадалтай шууд	2018-2020	Ангилжруулсан төмрийн үйлдвэр-1,	ТЭЗҮ болон БОННУ хийж эхэлсэн	Ангилжруулсан төмрийн үйлдвэр ба гангийн үйлдвэр	Төслийн хүрээнд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь жилд 500.0 мянган тонн шууд ангилжруулсан төмрийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажил, гангийн үйлдвэрт өргөтгөл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэн	70	

			ангигруулсан төмрийн үйлдвэр, 350 мян.тн/жил хүчин чадалтай гангийн үйлдвэр		гангийн үйлдвэр-1		байгуулах ажлыг эхлүүлсэн байна.	жилд 350.0 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд төмрийн хүдрээс ган гарган авах технологийн судалгаа, түүхий эд, материалын болон технологийн туршилтууд, шууд ангигруулсан төмрийн үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэв. Мөн Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн ТЭЗҮ-ийг Канад Улсын “Hatch” компани хийж гүйцэтгэсэн ба “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ”-г Монгол Улсын “Экотон” ХХК болон “Ажид” ХХК, “Экосфер” ХХК-иуд гүйцэтгэн 2019 онд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Мөн хөрөнгө оруулалтын боломжтой хувилбаруудыг судалж байгаа ба “Hatch” компанийн боловсруулсан ТЭЗҮ-д тусгаснаар төслийн санхүүжилтэд 1.17 тэрбум ам.доллар шаардагдах юм. Одоогийн байдлаар төслийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй байна.		
19			Зүүн бүсэд 200.0 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний үйлдвэр, 50.0 тн/жил хүчин чадалтай гангийн үйлдвэр	2018-2020	Ширэмний үйлдвэр-1, гангийн үйлдвэр-1	ТЭЗҮ хийгдсэн.	Ширэм ба гангийн үйлдвэр байгуулагдсан байна.	“МДМУ” ХХК нь Дорноговь аймгийн Айраг суманд 200.0 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний үйлдвэр, 50.0 тн/жил хүчин чадалтай ган бөмбөлгийн үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2016 онд “Аж үйлдвэрийн яам” /хуучнаар/-ны Хүнд үйлдвэрийн шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр батлуулсан ба 2017 онд үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлсэн. 76x27x9 м хэмжээтэй дулааны боловсруулалтын цехийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн суурийн ажлын гүйцэтгэл 100%, 126x30x9 м цутгуурын цехийн барилга 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Мөн домен зуухны 120 м3 суурийн цутгалтын ажлыг эхлүүлсэн ба төмрийн	70	

								хүдрийн бөөнцөгийн талбайн газар шорооны ажлыг хийж гүйцэтгэв. Тоног төхөөрөмжүүдийг БНХАУ-д захиалан хийлгүүлж байгаа ба тээвэрлэлт таталт, угсралт суурилуулалтын ажлыг 2019 оны 1-р улиралд эхлүүлж 3 дугаар улиралд дуусган, туршилт тохируулгын ажлыг хийж, үйлдвэрийг 2019 онд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.		
20		Нийтийн тээврийн хэрэгслийн үйлдвэр, металл хийцийн эд ангийн үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх;	Судалгаа	2018-2020	Судалгааны тайлан	Нийтийн тээврийн хэрэгслийн үйлдвэр, металл хийцийн эд ангийн үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл хөгжөөгүй, цөөхөн хэт жижиг цехүүд ажиллаж байв.	Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх кластер, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөлийн талаар судалгаа хийх ажлыг зохион байгуулсан байна.	“Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөл” сэдэвт зөвлөх үйлчилгээний Үнэлгээний хороо 2018.04.24-ний өдөр хуралдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай 2018.05.17-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж, эцсийн тайланг 2018.12.13-ны өдөр хүлээн авсан.	70	
21		Хөнгөн үйлдвэрийг кластераар хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь, хэмжээг нэмэгдүүлэх;	Хөнгөн үйлдвэрийн кластер	2016-2020	Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 9%	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн байна.	ЗГ-ын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП” ОНӨТҮГ, “Налайхын барилгын материалын ҮТП” ОНӨТҮГ, “Эрдэнэ хүнс САМО” ХХК зэрэг байгууллагуудад Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцүүлж, 178 дугаар тогтоолоор 4 жилийн хугацаатайгаар тусгай зөвшөөрлийг олгосон. Эдгээр ҮТП-ууд нь кластерын зарчмаар ажиллах бөгөөд 2018 он байдлаар: Налайхын барилгын материалын ҮТП-ийн	70	

							<p>“Үерийн далангийн барилга байгууламж”-ийн 1 дүгээр ээлжийн ажлыг БХБ-ын сайдын 2018 оны багцаас 250.0 сая төгрөгөөр санхүүжүүлж, 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 2018/170 дугаар гэрээ байгуулан хэрэгжүүлж эхэлсэн, ажлын явц 10 хувьтай байна. Тус паркийн 4.64 км авто замын ажлын I ээлжийн санхүүжилтыг НИТХ-ын 2018 оны 4/13 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 888 дугаар захирамжаар 8,827.5 сая төгрөгийг 2018-2019 онд гаргахаар шийдвэрлэж, тус 2018 онд 1,800.0 сая төгрөгийн санхүүжилтээр газар шорооны ажлыг бүрэн гүйцэтгэсэн. Ажлын явц 30 хувьтай байна. Нийт 13 үйлдвэртэй гэрээ байгуулсан. Налайх дүүргийн 70 иргэнийг ажлын байраар хангасан.</p> <p>-“Монголын хөнгөн үйлдвэрийн кластерийн өнөөгийн байдал” онол практикийн бага хурлыг 2018 оны 12 дугаар сарын 18 нд ҮХГ-тай хамтран амжилттай зохион байгуулсан. Хөнгөн үйлдвэрийн салбарын кластерын ерөнхий онол, ирээдүйн чиг хандлага болон Монгол улсын онцлогт тохируулах арга замын талаар ШУТИС-ын эрдэмтэн судлаач эрдэмтэд илтгэл тавив. Салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, кластерийн хөгжлийг бэхжүүлэх талаар, Могол ноос ХХК, Блю скай ХХК, Жинст мөрөн ХХК-ны жишиг кластерийг танилцуулав.</p> <p><b><i>Нийт экспортод боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь 2017 онд 10.8 хувь байсан бол 2018 онд 11.3 хувь болж, 0.5 хувиар өссөн байна.</i></b></p> <p>Дундговь, Төв аймгийн хонины ноосоор Могол ноос ХХК утас ээрч, ээрсэн утсаа Блю скай ХХК-д өгч даавуу үйлдвэрлүүлж, зузаан драпаар нь пальто, нимгэн даавуугаар нь дээрх 2 аймгийн сурагчийн дүрэмт хувцас болон ажлын хувцас үйлдвэрлэн кластерийг бий</p>	
--	--	--	--	--	--	--	--	--



								болгосон. Энэ ажлын хүрээнд 590 мянган сурагчийн дүрэмт хувцас, 1000 ширхэг ноосон пальто үйлдвэрлэж зах зээл борлуулсан байна. Мөн Жинст мөрөн ХХК, Сноүфильдс ХХК-ууд нь Ховд, Хөвсгөл аймгуудаас сарлагийн хөөвөр, ноолуур бэлтгэн авч, угааж, самнан эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж кластерын зарчмаар ажиллаж байна.		
22	“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлан хэрэгжүүлэх;	“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”	2017-2018	Үндэсний хөтөлбөр -1	ЗГ-ын 2014 оны 278 дугаар тогтоолоор баталсан.	“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийг шинээр боловсруулж, батлуулсан байна.	"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн төсөлд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн өөрчлөн боловсруулж байна. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах тухай журмын дагуу хөтөлбөрийн төсөлд яамдаас ирсэн саналыг тусгаж, хөтөлбөрийн төслийг 2018.06.13-ны өдрийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж гишүүдийн гаргасан саналыг тусган Сангийн яаманд 4 удаа хүргүүлэн ирүүлсэн саналыг тусгасан боловч Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулахтай холбогдуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал түр хүлээгдэж байна.	70		
23	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн чанар, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулан, ногоон технологид суурилсан экспортын баримжаатай бүтээгдэхүүн	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн чанар, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо	2017-2020	Бэлтгэн нийлүүлэлтийн цогц тогтолцоо-1	Түүхий эдийн гарал үүсэл тодорхойгүй, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо оновчгүйгээс түүхий эдийн чанарт муугаар	Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн цогц тогтолцоо бүрдсэн байна.	-Орон нутагт түүхий эд, тордолтын цэг байгуулах, түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх судалгааг хийлгэх зөвлөх үйлчилгээг “Бодлогын шийдэл” ТББ-аар, Арьс шир, ноос, ноолууран түүхий эд бэлтгэх, хадгалах, чанарыг хамгаалах үе шатанд мөрдөх стандарт, арга зүйн талаар видео сургалтыг “Толгой медиа” ХХК-иар тус тус гүйцэтгүүлэв. Архангай, Ховд, Завхан, Дундговь аймгуудад энэ чиглэлээр сургалт явуулсан.	70		

		үйлдвэрлэлийг хөгжүүлэх;				нөлөөлж байна.		-Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг сумдад байгуулах талаар малчдын бүлэг, хоршооны ажилтнуудад сургалт явуулж, АХБ-ны зээл тусламжаар техникийн тусалцаа үзүүлэн 56 хоршооны түүхий эдийн агуулахыг бэлтгүүлж, итгэмжлэл олгосон. -ШХА-ийн “Ногоон алт-малын эрүүл мэнд” төслийн хүрээнд Өвөрхангай аймагт 3, Хөвсгөл аймагт 3, Хэнтий аймагт 1, Баян-Өлгий аймагт 3 нийт 10 агуулахыг 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж, ашиглалтад оруулав. -ХХААХҮСайдын 2018 оны А-30 дугаар тушаалаар Баян-Өлгийн Баяннуурт 100.0 сая, Сэлэнгийн Жавхлантад 100.0 сая, Ховдын Жаргалантад 400.0 сая төгрөгөөр 1200 тн хүнсний ногооны зоорь байгуулахаар шийдвэрлэн тендер зарлан Гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан. -2019 оны төсөвт 30 суманд тордолтын төв байгуулах зардлыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгав.		
24		Аж үйлдвэрийн салбарын тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлэх;	Монгол улсын дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээний загвар	2016-2020	Нэгдсэн сүлжээний зураглал	Улсын хэмжээнд дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ байхгүй.	Аж үйлдвэрийн салбарын тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээ хөгжих боломж бүрдсэн байна.	2017 онд ҮХГазар, “Ложистикийн холбоо” ТББ хамтран Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Минис төслийн хүрээнд уул уурхайн салбарын тээвэр логистикийн нөхцөл боломжийн судалгааг хийлгэж хүлээн авсан. Уул уурхайн ордууд дээр түшиглэн Монгол улсын дэд бүтцийн нэгдсэн сүлжээний загварыг гаргаж, 1:7000000 масштабын зургийг гаргасан. Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах ажлын хүрээнд Үйлдвэржилтийн хөгжил, байршлын бодлогын судалгаа, Зам тээвэр, логистикийн хөгжил, байршлын судалгааны ажлуудыг ҮХГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-48, А-49 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулж, зөвлөх сонгон шалгаруулалтаар хийж гүйцэтгүүлсэн.	40	

25		<p>Чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, шинжлэх ухаан технологийн парк, хүнд аж үйлдвэрийн цогцолборуудын инженерийн дэд бүтцийг цогцоор нь барих үйл ажиллагааг дэмжих;</p>	<p>Аж үйлдвэрийн цогцолборууд, УТП-уудын инженерийн дэд бүтэц, ТЭЗҮ-ийн судалгаа</p>	2016-2020	<p>үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц-1</p>	<p>Аж үйлдвэрийн цогцолбор, УТП-уудын инженерийн дэд бүтэц, ТЭЗҮ-ийн шинэчилсэн судалгаа хийх шаардлагатай байна.</p>	<p>Аж үйлдвэрийн цогцолбор, УТП-уудын инженерийн дэд бүтцийг барьж байгуулсан байна.</p>	<p>“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2017 оны 173 дугаар захирамжаар байгуулсан. ЗГ-ын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Эмээлтийн арьс ширний УТП-ийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх асуудлыг хэлэлцүүлж, 15 дугаар тэмдэглэл гарган “Эмээлт хөнгөн үйлдвэрийн УТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг Концессийн тухай хуульд нийцүүлэн зохион байгуулах боломжийг судалж, шийдвэрийн төслийг боловсруулж ЗГ-т танилцуулахыг ҮХГ-т даалгасны дагуу ХХААХҮЯ, Нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх төслийн нэгжээс паркийн төсөл тооцооллыг боловсруулж ҮХГ-т хүргүүлсэн. Налайхын барилгын материалын УТП-т 2017 онд паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Тус парк нь үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган паркийн ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ болон дэд бүтцийн зураг төслүүдийг хийж гүйцэтгэн, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор паркийн нэгжээр ажиллах аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж байна. Өнөөгийн байдлаар тус парк нь 6 аж ахуйн нэгжийг бүртгэсэн бөгөөд эдгээрээс 5 аж ахуйн нэгж үйлдвэрийн барилга байгууламжийн суурийн ажлыг эхлүүлж, “Пийс стийл групп” ХХК нь 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрийн барилга байгууламжаа барьж, тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулсан байна. Мөн түүнчлэн Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр УБ-Чойрын замаас тус парк хүртэл нийт 4,67 км авто зам баригдахаар болж гүйцэтгэгч компаниуд ажлаа эхлээд байна.</p>	70	
----	--	---	--	-----------	--	---	--	---	----	--

							<p>Эдгээр паркууд нь дэд бүтэц хөгжсөн, түүхий эд нөөцдөө ойр томоохон хотуудыг түшиглэн байгуулагдсан бөгөөд цаашид хоорондоо хоршиж ажиллах, кластераар хөгжих боломж бүрдсэн.</p> <p><u>Хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд:</u>  Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт "Баянговь нутаг" ҮТП-ийг байгуулах асуудлыг ЗГ-ын 2015 оны 193 дугаар тогтоолоор ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. УУХҮЯ нь паркийн удирдлагатай гэрээ байгуулан ажиллаж байна.</p> Багануур дүүрэгт ҮТП байгуулах асуудлыг ЗГ-ын 2016 оны 272 дугаар тогтоолоор ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Тус паркийг байгуулж, хөгжүүлэх хүрээнд дараахь ажлууд хийгдэж байна. Үүнд: -Паркийн эзэмшлийн 414 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтцийн иж бүрэн зураг төсөл боловсруулах ажлууд хийгдэж байна. -Шаардлага хангасан 3 аж ахуйн нэгжийг паркийн нэгжээр бүртгэсэн байна. Үүнд: Хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд Япон улсын хөрөнгө оруулалттай “Силкроуд Аёори Монгол” ХХК-ийн хэрэгжүүлэх Ноос, ноолуур гүн боловсруулах төсөл, Ургамал nano биотехнологийн бүсэд дотоодын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Монхимо” ХХК-ийн “Адуу” брэнд төсөл, Хүнд үйлдвэрлэлийн бүсэд Герман улсын хөрөнгө оруулалттай “Монгол шингэн нүүрс” ХХК-ийн “Нүүрснээс түлш үйлдвэрлэх КДВ 5000” төсөл -Холбогдох судалгааны ажлууд хийгдэж байна. Дархан, Эрдэнэт хотод ҮТП-ийг байгуулж, хөгжүүлэх асуудлыг ЗГ-ын 2017.08.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 242 дугаар тогтоолоор үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

								<p>Тус паркууд нь яамтай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.</p> <p>Орон нутагтай хамтран ажиллаж, паркийн дэд бүтцийг өргөтгөхөд шаардлагатай зураг төслийн ажлуудыг хийсэн.</p> <p>Паркийн газар нутгийг орон нутгийн ИТХ-аар баталгаажуулсан.</p> <p>Паркт шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр олон улсын форум зохион байгуулах зэрэг ажлуудыг хийсэн.</p> <p>Паркт эхний ээлжинд ажиллах нэгжүүдийг сонгон шалгаруулж бүртгэсэн.</p> <p>Паркийн үйл ажиллагаанд шаардлагатай, хөрөнгө оруулалтын болон холбогдох судалгааг хийсэн.</p>		
26		<p>Үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцэд ногоон эрчим хүч ашиглах, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих.</p>	<p>Шинэ технологи нэвтрүүлэх төсөл</p>	2016-2020	<p>шинэ технологи-1</p>	<p>Үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцэд ногоон эрчим хүч ашиглах, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологи нэвтрүүлэлт хангалтгүй</p>	<p>Шинэ технологи нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна.</p>	<p>UNIDO-ийн төслийн экспертэй хамтран арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд байгаль орчны стандартын хэрэгжилтийн талаар үнэлгээ хийж, зөвлөмж гаргав. Зөвлөмжийг холбогдох яам, агентлаг, үйлдвэр, аж ахуйн нэгжид хүргэв. Дээрхи сэдвээр 2018.05.25-26-ны өдрүүдэд арьс ширний үйлдвэрүүд болон холбогдох төрийн болон ТББ-ын 70 хүнийг хамруулан сургалт семинар зохион байгуулж мэдээллийг түгээв.</p> <p>“Дахин ашиглах цэвэрлэсэн усны техникийн шаардлага” стандартыг боловсруулж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23 дугаар тогтоолоор батлав.</p> <p>-Технологийн түвшингийн үнэлгээ хийх журмын төслийг боловсруулж байна.</p> <p>- Хамгийн их бохирдол гаргадаг “Арьс ширний үйлдвэрийн хаягдал усны стандарт, боловсруулсан арьс ширэнд агуулагдах хорт бодисыг тодорхойлох аргачлал” судалгааг Монголын хог хаягдал дахин боловсруулах үндэсний холбоо/ХХДБҮХ/-оор хийлгүүлсэн.</p> <p>“Ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрлэлээс хаягдал ус, түүнийг дахин</p>	40	

								<p>ашиглах” нь судалгааг Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгээр гэрээлэн хийлгүүлсэн.</p> <p><u>УХГ-аас</u></p> <p>ЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 3.1.1.17. усны хайгуул, судалгаанд үндэслэн услалтын систем шинээр барих, сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх;</p> <p>3.2.2.6. уул уурхайн үйлдвэрлэлд хэрэглэж байгаа усны дахин ашиглалтыг нэмэгдүүлж, бүрэн тоолууржуулах;</p> <p>3.2.3.6. Оюутолгой, Тавантолгой, Цагаан суварга, Нарийнсухайтын бүлэг ордыг түшиглэн байгуулах уул уурхайн үйлдвэрүүд, тэдгээрийг даган бий болох хот, суурины усны хэрэглээг нарийвчлан тогтоож, үйлдвэрлэлийн болон ундны усаар хангах төслийг хэрэгжүүлэх.</p> <p>3.1.2.11-т “говийн бүсэд ногоон бүс байгуулах, түүнд түшиглэн өрхийн аж ахуйг хөгжүүлэх “Ногоон морь” төсөл хэрэгжүүлж эхлэх.” гэсэн арга хэмжээг тусгасны зэрэгцээ Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт “Сонгино говь”, “Ногоон морь” төслийг тусгаж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>		
	Зорилт 3-ын хэрэгжилт	<p>Дүгнэлт: Хүнд үйлдвэрийн чиглэлээр хийгдэх томоохон ажлуудыг эхлүүлсэн байна. Үүнд: зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулах, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулсан, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн гангийн үйлдвэрт өргөтгөл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэн жилд 350.0 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.</p> <p>Орон нутагт түүхий эд, тордолтын цэг байгуулах, түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх судалгааг хийлгэсэн. 4 аймагт гадаадын төслөөр 10 агуулах, мөн 56 хоршоонд дэмжлэг үзүүлж түүхий эд бэлтгэн нийлүүлэх агуулахын итгэмжлэл олгосон. Хөнгөн үйлдвэрийн кластераар хөгжүүлэх ажлын хүрээнд орон нутгаас /Төв, Дундговь/ үйлдвэрлэлийг дэмжиж, малчдаас хонины ноосыг үйлдвэрт нийлүүлэх Засаг даргын захирамж гарган, тухайн түүхий эдээр утас ээрч, даавуу үйлдвэрлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлдвэрүүд кластерын зарчмаар ажиллан дотоодын зах зээлд нийлүүлж эхэлсэн байна.</p>					59.1			
27	Дэвшилтэт техник,	Инноваци, өндөр технологи, нэмүү	Шинэ технологи	2018-2020	төсөл-1	Аж үйлдвэрийн	экспортын бүтээгдэхүүнд	2018 оны байдлаар хог хаягдал дахин боловсруулдаг 16 үйлдвэр ялган бэлтгэдэг		

<p>технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх</p>	<p>өртөг шингэсэн бүтээгдэхүүний судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих</p>	<p>нэвтрүүлэх сургалт, судалгааны төсөл</p>			<p>салбарын бүтэц уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдэд тулгуурласан хялбар технологи дээр суурилсан ба экспортын бүтээгдэхүүний 95 орчим хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн байна.</p>	<p>нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>206 цэг ажиллаж байна. “Шангила” зочид буудлын хог хаягдлыг анхан шатны ангилан ялгах менежментийг МХХДБҮХолбоотой хамтран 2018 оны 05 дугаар сард хийж, ялгасан хоёрдогч түүхий эдийг холбогдох дахин боловсруулах үйлдвэр өөрийн тээврээр авч байх зохицуулалт хийсэн. Эко парк байгуулах ТЭЗҮ батлагдаагүй боловч түүний дагавар үйлдвэрүүдийн ажлын зураг, дэд бүтэц, дэд өртөөний ажлын зураг батлагдсан.</p> <p>“Protein trade” ХХК нь яс дахин боловсруулах үйлдвэрийг Италийн Impianti sarrere компанийн бүрэн автомат тоног төхөөрөмжийг суурилуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>Тус үйлдвэр нь өдөрт 96 тн түүхий эдийг боловсруулж 24 тн тэжээлийн уураг, 17 тн малын гаралтай тос үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 140 градусын өндөр температурт ариутгал хийдэг учир эцсийн бүтээгдэхүүн дээд зэргийн чанартай гардаг. Малыг гаралтай тосыг техникийн тос, бусад төрлийн тослох материал, саван, глицерин, бүх төрлийн лак зэрэг өргөн хэрэглээний үйлдвэрлэлийн түүхий эд болдог. “Өндөр ахын өргөө” ХХК нь Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэгт БНХАУ-ын 100 % хөрөнгө оруулалттай, хоногт 10 тн хуванцар сав дахин боловсруулж хуванцар түүхий эд бэлтгэх хүчин чадалтай үйлдвэр байгуулагдан технологийн туршилтаа хийгээд байна. Тус үйлдвэр бүтээгдэхүүнээ БНХАУ-ын Хэбэй мужид экспортлох юм.</p> <p><b>Монпеллетс” ХХК</b> нь Монгол хурганы болон ахрын ноосоор <b>био бордоо</b> үйлдвэрлэн Берлин хотын Хумболдын Их сургуультай 2005-2007 онд хамтран технологи инновацийн бүтээгдэхүүн гаргасан. Төв аймгийн Эрдэнэ суманд орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж суурилагдсан үйлдвэрээ 2018 оны 9-р сард байгуулан, Герман Япон, Солонгос болон</p>	<p>70</p>	
--	---	---	--	--	--	--	--	-----------	--

							<p>дотоодын зах зээлд нийлүүлж байна. Уг бордоо нь экологийн цэвэр бүтээгдэхүүнээс гадна ургацыг 2-3 дахин нэмэгдүүлдэг, баруун Европ, Азийн зарим оронд экспортод гардаг, зах зээлийн өндөр үр ашигтай инновацийн бүтээгдэхүүн болоод байна.</p> <p>Уламжлалт үндэсний монгол дээлийг орчин үеийн нано технологиор гарган авсан гал болон ус нэвтэрдэггүй материалаар <b>“Хадлан”</b> дээлийг <b>“Three flames” ХХК</b> ны загвар зохион бүтээгчид бүтээн, инновацийн эрэлт өндөр бүтээгдэхүүн болоод байна. Дотоод зах зээлээс гадна АНУ, Герман, Францад эрэлттэй, борлуулалт өндөр бүтээгдэхүүн болсон.</p> <p>Бүх төрлийн ахуйн хог хаягдал, нүүрсийг шатааж, ахуйн хэрэглээний газ үйлдвэрлэн, дулааны энерги гаргах <b>“АББАТ”</b> /Ахуйн бохирдлыг бууруулан ашиглах төсөл/-ийг дэмжин хэрэгжүүлэгч <b>МегаВүүд ХХК</b>-д санхүүгийн дэмжлэг үзүүлж АХБ болон Монгол банкны удирдлагыг газар дээр нь очиж үзүүлэв.Уг төслийн туршилтын арга хэмжээ амжилттай болсон. Дээрх төсөл нь агаарын болон орчны бохирдлыг бууруулах, дулаан эрчим хүч үйлдвэрлэх эдийн засгийн болоод нийгмийн өндөр үр ашигтай чухал төсөл юм. Мөн тус компани нь ойгоос гарах хаягдлыг ашиглан инновацийн бүтээгдэхүүн <b>МД хавтанг</b> 2-3 төрлөөр үйлдвэрлэхээр үйлдвэрлэлийн барилгаа барьсан.</p> <p>ХХААХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн Сайдын нэрэмжит грантыг <b>“Хагас нарийн ээрэх системээр үйлдвэрлэсэн 48/2 номерын ноолууран ээрмэлээр сүлжсэн оёдолгүй, дотуур сүлжмэл бүтээгдэхүүн”</b> зэрэг 5 бүтээлд олгов. ХХААХҮ-ийн салбарын хэрэгжүүлэх боломжтой судалгаа, зүгшрүүлэлтийн ажил /инновацийн төсөл/-ын Хөдөө аж ахуйн -22, аж үйлдвэрийн салбарын 8 төслийн ирүүлснээс Шилдэг</p>	
--	--	--	--	--	--	--	---	--



								инновацийн бүтээгдэхүүн"-ээр Мал эмнэлгийн хүрээлэнгийн "Тарааны ветбиотек" компаний "Делтамон Пу-Рон" /малын гадна шимэгчийн эсрэг үйлчилгээтэй дусаалга эм/ шалгарч 60,0 сая төгрөгөөр шагнуулсан. Голланд Улсын 60 хувийн хөрөнгө оруулалттай MiM ХХК-ийн адууны дэл сүүлний үйлдвэр байгуулагдав. Уг үйлдвэрт 30-40 иргэн, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах боломжтой боллоо.		
28		Төр болон шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжиж, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2016-2020	инновацийн бүтээгдэхүүн	Экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төр болон шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоо сул байна.	Төр болон шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулсны үр дүнд экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоолоор ""Үндэсний инновацийн шагнал олгох журам"" батлагдсан. Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнд "Тарааны био ундарга" ХХК-ий "Ризо" шингэн бордооны үйлдвэр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. <i>Шингэн бордооны хувьд ашиглаж, түгээхэд хялбар, үр дүн сайтай. Уг бордоог ашигласнаар үрт ургамлуудыг 10-20 хувь, төмсийг 15-25 хувь, улаан лооль, өргөст хэмх зэрэг нарийн ногоог 20-40 хувь хүртэл ургацыг нэмэгдүүлэх боломжтой. Энэхүү үйлдвэр нь жилдээ 300 тонн шингэн био бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай юм.</i> Салбарын эрдэмтэн судлаачдыг дэмжих зорилгоор зохион байгуулж буй Сайдын нэрэмжит грантын шалгаруулалтад ирүүлсэн бүтээлүүдийг Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шалгаруулж, ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А-120 дугаар тушаалаар нийт 5 бүтээлд "Сайдын нэрэмжит грант" олгосон.	70	
	<b>Зорилт 4-ийн хэрэгжилт</b>	Дүгнэлт: Инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн болон дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд өмнөх онтой харьцуулахад тодорхой үр дүнд хүрсэн байна.						<b>70.0</b>		
29	Мэдлэгийн менежментийг	Соёлын салбарын	Соёлын болон бүтээлч аж	2016-2020	төсөл-1	Соёлын салбарын	Соёлын болон бүтээлч аж	Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг шинэ хэлбэрээр илэрхийлэн танилцуулах	100	

	хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, шинэ чадавх, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох	статистикийг нэвтрүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;	үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр төсөл			статистик үзүүлэлт тодорхойгүй, соёлын үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ бага	үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлсэн байна	замаар хөхиүлэн дэмжих, орон нутгийн бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжих боломжийг дэмжиж чадавх стратеги болон практик хүрээг бий болгох зорилгоор ЮНЕСКО, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр “Соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, соёлын олон төрөл зүйл-Монголын гар урлалын үйлдвэрлэлийг чадавхжуулах нь” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн үр шимийг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэний нийгэм, хувийн хэвшил, соёлын салбарын мэргэжилтнүүд, гар урлалын холбоод, үйлдвэрлэгчид хүртэх юм.		
30		Үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож хөгжүүлэх.	Үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүний жагсаалт	2016-2020	шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ-1	Үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ төдийлэн дэлгэрээгүй байна.	Үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгож, соёлын биет болон биет бус өвүүдийг ЮНЕСКО-ийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн байна.	Бүгд Найрамдах Солонгос Улсын Жэжү арал дээр 2017 оны 12 дугаар сарын 4-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ЮНЕСКО-ийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенцийн Засгийн газар хоорондын хорооны 12 дугаар чуулганаар яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад Монгол Улсаас нэр дэвшүүлсэн “Уул, овоо тахиx монгол зан үйл”-ийг амжилттай бүртгүүллээ. 2018 онд : -Айраг исгэх уламжлалт зан үйл, - Бурхан халдун уул түүнийг хүрээлсэн газар нутгийг соёлын ангиллаар, - Монгол дагуурын талыг байгалийн өвийн ангиллаар тус тус бүртгүүлсэн.	100	
	<b>Зорилт 5-ын хэрэгжилт</b>	<b>Дүгнэлт:</b> Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой үр дүнд хүрч, үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгож, соёлын биет болон биет бус өвүүдийг ЮНЕСКО-ийн өвийн жагсаалтад 3 биет бус өвийг бүртгүүлсэн байна.						<b>100.0</b>		
31	Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүч бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин,	Инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, чадавхжуулах	Судалгаа, сургалт	2018-2019	Судалгаа-2	Салбарын инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх	Боловсруулах үйлдвэрийн салбарын инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг	Монгол-Германы ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу ХБНГУ-ын талын хүсэлтээр хөнгөн үйлдвэрийн салбарын инженерүүдийн хэрэгцээ, хангалтын судалгааг гаргаж хүргүүлэв. ЗГ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.53 дахь заалтын дагуу хөнгөн жижиг дунд үйлдвэрийн “Мэргэжилтэй ажилтан”	70	

	нөхцөлийг бүрдүүлэх.	тогтолцоог сайжруулах;				чиглэлийн судалгаа	бэлтгэх чиглэлээр судалгааг зохион байгуулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.	хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ ТНБД-ын А-430 тушаалаар батлуулан холбогдох судалгаа, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны дэргэдэх Мэргэжлийн боловсрол, сургалтын зөвлөлийн хөнгөн үйлдвэрийн салбарын Ажлын хэсгийг байгуулав. Говь, Гоёо зэрэг томоохон үйлдвэрийн хүний нөөцийн менежерүүд оролцсон зөвлөгөөнийг 2018 оны 11 дүгээр сард ХНХЯ, МАОЭНХ-той хамтран зохион байгуулав. Экспортыг дэмжих төсөл, ШУТИС-ийн “Shima Seiki Training center” сургалтын төв болон Японы Shima Seiki фирмийн “Total Design Center” төвтэй хамтран сүлжмэлийн АРЕХ 3-3 дизайн системийн ахисан түвшний сургалтыг явуулсан. Сургалтад 20 гаруй үйлдвэрийн дизайнерууд хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэн Японд олгодог сертификатыг Монголдоо авсан байна. <u>УУХҮЯ:</u> Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн нэгж, Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслийн нэгжүүд хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжих томоохон төслүүдийн хүний нөөцийн талаарх судалгааг хийсэн бөгөөд цаашид хүний нөөцийг системтэй бэлтгэх зорилгоор Төслийн нэгжүүд инженер, техникийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулиудтай санамж бичиг байгуулан ажиллаж байна.		
32			2018-2020	Сургалт-1		Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг зохион	Төслийн нэгжүүд хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжих томоохон төслүүдийн хүний нөөцийн талаарх судалгааг хийсэн бөгөөд цаашид хүний нөөцийг системтэй бэлтгэх зорилгоор инженер, техникийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулиудтай санамж бичиг байгуулан ажиллаж байна. ШУТИС-тай хамтран Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд хими, металлург, механик инженерийн чиглэлээр	100		

						байгуулсан байна.	"мэргэшсэн", "зөвлөх" инженерийн эрх олгох сургалтыг 2018 оны 3,4 дүгээр сард зохион байгуулсан.		
33			2017-2020	МСҮТ-1		Хөнгөн үйлдвэрийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг МСҮТ-тэй уялдуулах	Хөнгөн үйлдвэрийн боловсруулах үйлдвэрийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх хүрээнд МСҮТ-ийн Чадавхид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, БСШУСЯ-д хүргүүлэв. Мөн энэ чиглэлээр улсын төсвөөр МСҮТ-ээр бэлтгэгдэж буй мэргэжилтэй ажилчдыг үйлдвэрүүдийн эрэлттэй уялдуулан зохицуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн хөтөлбөрийн зорилт болгон тавьж, хөнгөн үйлдвэрийн 14 салбарын хүний нөөцийн судалгааг гаргахаар зөвлөх үйлчилгээг зарлах ажлыг төлөвлөлтөд тусгаад байна.	40	
34		Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл"-д орсон нэмэлт	2018-2019	Жагсаалт-1	Хөнгөн үйлдвэрийн машин ашиглалтын инженер, Арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийн хими технологи, Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи мэргэжил үйлдвэрлэлд нэн шаардлагатай байгаа ч элсэлт цөөхөн байна. Дээрхи мэргэжлээр суралцагчид мэргэжлээ	Хөнгөн үйлдвэрийн машин ашиглалтын инженер, Арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийн хими технологи, Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи мэргэжлээр хангагдах нөхцөл бүрдсэн байна.	Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл"-д хөнгөн үйлдвэрлэл, нийтийн хоолны 21 мэргэжлийн инженер, технологич мэргэжлээр элсэгчдэд тэтгэлэг олгох журамд өөрчлөлт оруулах тухай саналыг 2018 оны 05-р сарын 18-ны ХХААХҮ-ийн Дэд сайдын 01/1809 тоот албан бичгээр БСШУЯ болон ШУТИС-ийн ҮТС-д хүргүүлсэн .	70	

						солих явдал байна.				
35		Ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.	Ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх аян	2016-2020	Зохион байгуулсан аян-1	Ажиллах орчин, нөхцөл бүрдээгүй-гээс ажилчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байна. Хөдөөнөөс хот руу шилжилт хөдөлгөөн их байна.	Ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах орчин, нөхцөлийг сайжруулсан байна.	Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилгот хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, иргэдийг орон нутгаас хот суурин руу чиглэсэн хөдөлгөөнийг багасгах, нийслэл хотоос орон нутагт шилжин суурьшиж шинээр мал аж ахуй, газар тариалан, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх иргэдийг санхүүгийн болон санхүүгийн бус хэлбэрээр дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулан, агаарын бохирдлыг бууруулахад нөлөө үзүүлэх зорилготой аян зохион байгуулах бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас хот суурин руу чиглэсэн хөдөлгөөнийг багасгах, нийслэл хотоос орон нутагт шилжин суурьшиж шинээр үйлдвэрлэл эрхлэх асуудлыг тусгаж оруулсан. -Говь ХК жилд 2000 тн ноолуур самнах хүчин чадалтай, анхан шатны үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн суманд байгуулахаар 17 га газар авч, шав тавин энэхүү бүтээн байгуулалтын хүрээнд ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр 1000 ажилчдын орон сууцыг эхлүүлэхээр төлөвлөсөн байна. -Хөнгөн үйлдвэрийн салбарын өнөөгийн байдлыг тогтоох зорилгоор 11 салбарын 500 орчим үйлдвэрүүдээс ИТА болон мэргэжилтэй ажилтаны судалгааг авахаар анкет боловсруулаад байна. Хөнгөн үйлдвэрийн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжоор хангах зорилгоор “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр боловсруулан батлуулах Ажлын хэсгийг ТНБД-ын А-430 тогтоолоор батлан	40	

								гаргаж, олон нийтийн болон их дээд сургуулиудын оролцоотой хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулав. Хөтөлбөрийг 2-р улиралд ЗГ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.		
	<b>Зорилт 6-ын хэрэгжилт</b>	Дүгнэлт: Үйлдвэрийн инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр холбогдох сургалтад хамруулж байгаа хэдий ч системтэй аж үйлдвэрийн салбарын хүний нөөц мэргэжилтнй ажилтан бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр “Мэргэжилтнй ажилтан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна.							<b>64.0</b>	
								<b>Дундаж үнэлгээ</b>	<b>73.4</b>	